Хичээл-Уран зохиол

Анги – 9

Судлах цаг – 7 хоногт 1 цаг

Уран зохиолын нийт судлах бүлэг сэдвийн тоо – 4

1. Сонгодог уран зохиол – Гэсэр, МНТ
2. Яруу найраг – шүлгүүд
3. ҮҮЗ – өгүүллэг, тууж, роман
4. Жүжгийн зохиол

**9-р ангийн уран зохиолын хичээлийн агуулга, сурагчдын эзэмших чадвар, уншиж судлах эх**

| | Эзэмших чадвар | Хэл зүй | Уншиж судлах эхүүд |
|---|---|---|---|
| Унших | - Монголын эртний тууж, түүхэн сурвалжаар уламжилсан яруу найраг, тууль, бэсрэг роман, жүжгийн зохиолоос сонгон уншиж, соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авах<br>- Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл (бэлгэдэл) -ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлах<br>- Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдпын өнгөрснийг дурсах, | - Монголын эртний тууж, түүхэн сурвалжаар уламжилсан яруу найраг, тууль, бэсрэг роман, жүжгийн зохиол<br>- Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл (бэлгэдэл) -ийн учир холбогдол<br>- далд утга<br>- Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдпын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөө<br>- Зохиолын утга санааг бүрдүүлэх сэдэв, хам сэдэв<br>- Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдэв утгыг тодруулах<br>- Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарал дүрийн өсөлт | - Монголын эртний тууж, түүхэн сурвалжаар уламжилсан яруу найраг, тууль, бэсрэг роман, жүжгийн зохиол<br>- Шүлэглэсэн зохиол |

| | | | |
|---|---|---|---|
| | ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлах<br>- Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх<br>- Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдэв утгыг тодруулахад нөлөөлж буйг шинжлэх<br>- Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэх<br>- Шүлэглэсэн зохиолын шад, холбоц, бадаглалын туршлагыг шинжлэх | - Шүлэглэсэн зохиолын шад, холбоц, бадаглал | |
| Бичих | - Уншсан зохиолын сэдэв, утга санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичих<br>- Уншсан зохиолын сэдэв, утга санаа, дүр, дүрслэлээс сонгон, баримт жишээ ашиглан үнэлж дүгнэх<br>- Дүр, орчныг хувирган, үйл явдлыг төгсгөн, богино өгүүллэг зохиох | | |
| Ярих сонсох | - Бие даан уншсан зохиолыг бусдад унших хүсэл төрөхүйц, | | |

| | | | |
|---|---|---|---|
| | сонирхолтой арга хэлбэрээр танилцуулан илтгэх<br>- Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцэх | | |